НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 19 өдөр Дугаар А/43 Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт
халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,
хяналт тавьж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30, 39, 62, 63 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168, А/191 дүгээр захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 2, 3, 4, дүгээр хурлын шийдвэр, "Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм"-ийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой комиссын орлогч дарга Ж.Батбаясгалангийн баталсан "Шинэ төрлийн коронавирус /covid-19/-ийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч эргүүлээр ажиллах хуваарь"-ийн дагуу Сүхбаатар дүүргийн хуваарьт талбайд шинэ коронавирусийн халдвар, томуу, томуу төст өвчний тархалтаас сэргийлэх эргүүлийн ажлыг Даваа-Баасан гарагт 10:00-22:00 цаг, Бямба, Ням гарагт 11:00-19:00 цагийн хооронд зааврын дагуу ажиллах үүрэг бүхий албан хаагчдын хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дүн мэдээг өгөгдсөн хүснэгтийн дагуу боловсруулж өдөр бүрийн 21:00 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шуурхай штаб /Утас: 11-324207/-т тайлагнаж цахим шуудангаар хүүргүүлж ажиллахыг нийт албан хаагч нарт даалгасугай.

3. Урьдчилан сэргийлэх ажилтай холбогдон гарсан зардлыг зохих сангаас зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тухайн ажлын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

1119282495 ,4.2576589

115070200119